

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-16
<hr/>	
1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлт	3-9
2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/	9-16

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 08 дугаар сарын 15-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 28 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Тасалсан: Х.Баттулга, Б.Бат-Эрдэнэ, Д.Ганбат, Л.Мөнхбаатар, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг танилцуулав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Н.Алтанхуяг, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Цагдаагийн албаны тухай хуулийн 26.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 13 дахь заалтын “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ...” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Цагдаагийн албаны тухай хуулийн 26.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэдийнхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4

Бүгд: 16
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, С.Эрдэнэболд, Дам.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: “Хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 57 минут үргэлжилж, 22 гишүүнээс 16 гишүүн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их засаг” танхим,
15 цаг 28 минут

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Дам.Цогтбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийг мэндийг эрвэ. Ингээд Хууль зүйн байнгын хорооны хуралдаан 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирц 59,1 хувьтай байна. Ирцэд Дамдины Цогтбаатар гишүүн, Жуковын Алдаржавхлан гишүүн, Норовын Алтанхуяг гишүүн, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн, Пүрэвжавын Сайнзориг гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Гончигдоржийн Уянгахшиг гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн гэсэн ийм ирцтэйгээр ирц бүрдсэн байна. Ингээд хуралдааны ирцийг танилцууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал хэлэлцэхээр ярьж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлт /Цагдаагийн албан тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай/ 1 дүгээр асуудал,

2 дугаар асуудал бусад асуудал гэсэн ийм зарчимтайгаар 2 асуудал хэлэлцэх саналтай байна.

Хэлэлцэх асуудлаар санал хэлэх гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудлыг баталлаа. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

1 дүгээр асуудал. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлт /Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Монгол Улсын үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/ асуудлыг авч хэлэлцэнэ.

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулгыг би өөрөө танилцуулна.

Би ингээд нөгөө материалуудаа тараачихсан байгаа учраас Үндсэн хуулийн цэцээс гаргасан шийдвэрийн дүгнэлтийг уншаад танилцуулчихъя.

Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг “энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж тус тус заасныг зөрчсөн байна.

2.Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт “энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд байранд хүргэснээс эхлэн тооцно.” гэж заасныг Үндсэн

хуулийн цэцэд маргаан шийдвэрлэ хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй гэж заасан байгаа юм.

Мөн түүнчлэн энэ дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсан байна. Ингээд энэ тухай танилцуулгыг бол хийлээ. Бусад танилцуулга та бүгдэд тараагдсан байгаа.

Энэ асуудлаар асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Тэгвэл цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. Сайнзориг гишүүнээр Уянгахуушиг гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 03 тоот Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороо хүлээн авах нь зүйтэй байна гэсэн ийм саналтай байна. Би бол бас энэ цэцийн дүгнэлтэд олзуурхаж харсан 1 асуудал бол хэдийгээр Цагдаагийн албаны тухай хуулийн нэг зүйл заалтын 4 үг Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаан шийдвэрлэсэн хүрээг ярьж байгаа боловч миний зүгээр лав парламентын гишүүнээр ажиллаж байх хугацаанд Цэцээс үндэслэл хэсэг нь ийм дэлгэрэнгүй бөгөөд тодорхой бас онолын үндэслэл сайтай, харьцуулсан судалгаанд үндэслэсэн, олон улсын эрх зүйн хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг судалж мөн эшилсэн дүгнэлт бол бас цөөхөн тааралдаж байсны нэг нь бол энэ дүгнэлт байна гэж ингэж үзэж байна.

Энэ дүгнэлтийг гаргасан Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүнийг бас хараад байж байна л даа. Тэгээд энэ дүгнэлтийг гаргахад Үндсэн хуулийн цэцийн дарга Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Эрдэнэбулган, Гангабаатар, Мөнхсайхан, илтгэгч Н.Мөнхсайхан гишүүн байна. Энхтуяа нарын бүрэлдэхүүнтэй оролцож дүгнэлтээ гаргасан юм байна. Тэгэхээр үндсэндээ Монгол Улсын бас Үндсэн хуулийн шүүх хэт орсон өөрчлөлтийн салхи бол бас үр дүнгээ өгч байгаа юм байна гэдгийг би энэ дүгнэлтээс бас харж, хувьдаа бас их олзуурхаж байгаа юм.

Тэр дотроо Монгол Улсын 2021 оны 1 сард баталсан Шүүхийн тухай шинэ хуулийн үр дүнд шүүх байгууллагаас Үндсэн хуулийн цэцэд илгээдэг байсан 3 квотыг Шүүхийн хуульд зааснаар Улсын дээд шүүхийн нийт гишүүд хуралдаж байж, нийт гишүүдийн олонхоор нууц санал хураалтаар цэцийн гишүүнийг Улсын Дээд Шүүх тодруулдаг болсон. Үүний үр дүнд Монгол Улсын Дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд илгээгдсэн.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Дөнгөж эхэлж байгаа юм байна. Нэг удаа зөөлөн хандана. Энхбаяр гишүүний микрофоныг өгчихье. Цаашидаа цагаа барина шүү манайхан.

Б.Энхбаяр: Уучлаарай. Эрдэнэбулган, Гангабаатар, Мөнхсайхан гээд бас онолын академик суурьтай гишүүд бас энэ Үндсэн хуулийн цэцэд орсон нь бол шууд мэдэгдэж эхэлж байна. Тийм учраас Үндсэн хуулийн цэцээс дараа дараа бас дүгнэлтүүд гарахдаа ийм тодорхой эш үндэслэл сайтай гарч байхад бас нэмэртэй юм байна гэж бодож байна.

Нэг саналтай байна. Дэгийн хуулийг бид одоо шинэчилнэ. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбоотойгоор зөвхөн Улсын Их Хурлаас томилогдсон

итгэмжлэгдсэн төлөөлөгч энэ цэцийн гишүүн нь гишүүдийн асуултад хариулдаг тийм дэгтэй байгаад байгаа юм. Энэ ерөөсөө болохгүй байгаад байгаа юм. Яагаад гэхээр Улсын Их Хурлаас томилогдсон хүн маань Үндсэн хуулиа зөрчөөгүй гэж хамгаалж очиж байгаа этгээд. Тэгээд Улсын Их Хурлын хамтын баталсан шийдвэрийг хамгаалж очдог. Гэтэл энэ шийдвэр чинь өөрөө Цэцийн дүгнэлтээс гишүүд асуух гээд байдаг. Цэцийн гишүүд үндэслэлээ бас хариулмаар байдаг. Тэгэнгүүт одоо Цэцийн халдашигүй байдал, бие даасан байдалд халдах гэж байна, нөлөөлөх гэж байна гээд энэ Улсын Их Хурал асуулт асуудаг энэ юмыг нь Цэц өөрөө Үндсэн хууль зөрчсөн гээд хаачихсан юм. Тийм учраас энэ цэцийн дүгнэлтээс гишүүд асуулт асууж, яагаад ийм дүгнэлт гаргасныг нь сайн имэрч тодруулж байж хүлээж авах эсэх, хүлээж авбал тэр хүлээж авсныхаа дараа холбогдох хуулиа өөрчлөх, засварлах, боловсронгуй болгох тэр санал гаргахад их дэмтэй байгаад байгаа юм. Тийм учраас энэ асуудлыг бас манай гишүүд шинэ дэгийг боловсруулах дээр Цэцийн дүгнэлттэй холбоотой асуудалд бас оруулж өгөх ийм асуудлыг би протоколд тэмдэглүүлж байна.

Дам.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг нь өгье.

П.Сайнзориг: Би энэ цэцийн дүгнэлтийг бас олон талаас нь бодолцож үзээсэй гэж бас хүсэж байгаа юм. Мэдээж хүний эрхийг хангах энэ чиглэл рүүгээ бид одоо бас олон боломжит бүх тэр хууль сахиулах үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа дэд бүтцүүдээ бүрдүүлж байж бас зарим зүйлүүд хэрэгжих бололцоотой гэдгийг бол ойлгож байгаа. Тэгэхдээ энэ зүйлийн бас үр дагаврыг бид хэд тооцохгүй бол өнөөдөр Монгол Улсын нутаг дэвсгэрийн онцлог байж байгаа. Нэлээн тархай бутархай, эргээд өргөн уудам газар нутагтай. Саатуулсан этгээдийг юу гэдэг юм, хөдөө хээр саатуулаад авлаа гэхэд яг яах вэ. Эсвэл юу гэдэг юм гав

зүүснээр ч гэдэг юм уу энэ нөхцөл байдал үүсэх үү. Эсвэл тэрийг саатуулагдсанд тооцох уу. Одоо ингээд яг нөхцөл байдлуудаа бид бас эргээд бодох юм бол бас аль аль талыг нь бас бодолцож бас авч үзэх ёстой юм. Тэгээд яах вэ, зүгээр энэ заалтыг хүлээгээд авлаа гэхэд бид энэ дээрээ бас нарийн нухацтай бас цаад талын ойлголтуудыг нь хийж өгөх зайлигүй шаардлага байна л гэж харж байгаа юм. Энийг бас хүчингүй болоод, цэцийн дүгнэлтийг хүлээж аваад энэ заалт хүчингүй боллоо гэхэд энэ 6 цагт амжиж тэр тухайн саатуулсан этгээдийг магадгүй тэр дэд бүтцэдээ хүрч чадаагүйгээс хэн бэ гэдгийг, ямар гэмт хэрэг шалгагдаж байгааг нь ч гэдэг юм уу энэ зүйлүүдийг нь бүрдүүлээгүй нь эргээд бас нөгөө хууль сахиулагч буцаад бас буруутгагдах ийм нөхцөл байдал руу орох байх.

Нөгөө талдаа гэмт хэргийг таслан зогсоох, эргээд энэ гэмт хэргийн хохирогч этгээд буцаад яг юу гэдэг юм хууль ёсонд итгэх үү. Амжсангүй гээд тавиад явах уу. Би бол яг энэ хуулийн заалтуудыг яг хууль боловсруулахад тал талаасаа ярьж байхад жишээ нь аймгийн төвөөсөө алслагдсан сумуудаасаа ирж байх явцаа энэ хугацаа дуусах магадлалтай. Тэгэхээр энэ хугацаа дууслаа гээд тэр хүнийг мотоцикл дээрээсээ буулгаад явах уу, эсвэл морьтой явж байхдаа буулгаад хээр үлдээх үү. Ийм ийм зүйлүүд бол байдаг юм байна лээ. Тэгэхээр одоо яах вэ, зүгээр мэдээж энэ асуудлуудыг шийдэх гарц бол хууль сахиулах албаны бас дэд бүтэц гэх үү, эсвэл хэрэглэгдэхүүн, тэр машин, мотоцикл нь бас яг саатуулах хэмжээний тэр хамгаалалттай ч юм уу ийм зүйлүүдээ хийж байж бас энэ зүйл бүрэн хэрэгжих юм байна лээ. Яах вэ зүгээр энэ сайхан дүгнэлт байна гээд авчихдаг. Дараа нь бол үр дагавар бас нэлээн бас өндөр шүү. Эргээд энэ гэмт хэрэгт хохирчхоод байгаа иргэд маань нүдэн дээр нь нөгөө хүнийг нь тавиад явуулах, шалгаж амжсангүй гээд явуулах ийм л зүйл

харагдах байх. Тэгэхдээ юм бол бас 2 талтай байгаа. Энийгээ бас зөв бодолцох нь зөв байх. Тэгээд энийг хүлээгээд авсан тохиолдолд бид одоо ямар хэмжээний засвар үйлчилгээг энэ хууль дээр оруулах асуудлыг бас эндээс нэлээн сайн ажлын хэсэг гараад нухацтай ярихгүй бол энэ жижиг юм шиг боловч бас нэлээн олон, 2 талын үр дагавартай ийм зүйл байгаа юм гэдэг зүйлийг л би зүгээр хэлмээр байна.

Дам.Цогтбаатар: Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Сайнзориг гишүүнтэй яг адилхан санал хэлэх гэж байсан юм. Одоо ингээд дүгнэлтээ харах юм бол Мөнх-Оргил гишүүний тухайн үед өгч байсан тайлбар нь байгаа. Тэгээд яг энэ дээр бол яг Сайнзориг гишүүний хэлсэнчлэн тухайн 6 цаг гэж тогтоосон шалтгаан бол тухайн түр саатуулах байранд тухайн хүнээс мэдээлэл авах, мэдүүлэг авах тэр хугацаагаа заагаад өгчихсөн байдаг. Гэтэл үнэхээр орон зайн хамаарлаас хамаараад, шалтгаалаад тэр 6 цагийнхаа хугацаанд очиж амжихгүй байдаг ч юм уу. Тийм ээ. Тэр 6 цаг чинь өөрөө зохицуулагдахгүй харилцаа болоод үлдчихэж байгаа учраас яг нөгөө цаад хуулийнхаа оруулсан 6 цагт түр саатуулах байранд хүргэж өгснөөс эхэлнэ гэдэг хугацааны процессыг тэрний цаана явж байгаа процессоо уялдуулахгүй бол яг энэ хуулийн заалт дангаараа хүчингүй болчихдог. Үүний цаана дараа нь энэ нөгөө цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсэх вэ гэдэг талаас нь бас анхаарч үзээсэй гэдэг саналтай байсан.

Дам.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье. Өнөөдөр бол эхний ер нь хуралдаанууд учраас энэ боломжуудыг олгож байгаа. Цаашидаа бол нэгэнт цаг хугацаатай ажлууд маань тэгээд тэр цаг хугацаандаа багтаж явна шүү. Өөрт чинь ч гэсэн би үг өгье.

Н.Алтанхуяг: Эрхэм гишүүдийн амрыг айлтгая. Энэ би энэ ажлын хэсэгт нь орж ажилласан юм. Яг энэ дээр бид нарын дунд бас маргаан гараад байсан юм. Тэгэхээр Сайнзориг оо, одоо энийг бид нар Үндсэн хууль зөрчсөн гээд хүлээгээд авчихаар яах вэ гэдэг бол дараагийн асуудал байхгүй юу. Бид нар Үндсэн хуулиа л зөрчиж болохгүй. Тэр 6 цагийн хугацааг их ярьсан юм бид нар. Тэгээд тэр яамны ажилтны зовлонгоор нь 6 цаг гээд хийчихсэн байхгүй юу. Үгүй ээ, нээрээ яадаг юм бол доо энэ чинь хэцүү юм байна. Тэгэхээр Үндсэн хууль дээр халдашгүй дархан байна л гэхчхэн юм чинь. Тэгээд халдашгүй дархан байдлыг нь зөрчиж л байгаа бол тэр моментоосоо эхлээд тоолохоос өөр арга байхгүй. Тэгээд бид нар Үндсэн хуулиа хамгаалах ёстой шүү дээ. Тэр байгууллагын зовлон цагдаа хөдөөгөө бол дараа нь л ярь л даа. Би тэр байр суурь дээр байгаа. Намайг нөгөө сүүлд ор гээд байсан. Үндсэн хуулийн цэц дээр оч гээд байсан. Энэ асуудал юм байна шүү дээ. Мөнх-Оргил гишүүн очиж байсан. Сонгуулийн үеэр. Тэгэхээр би болбол тийм байр суурьтай байгаа. Ер нь одоо манай Хууль зүйн байнгын хорооныхон юм ойлго. Үндсэн хуулийг зөрчсөн гэж байгаа бол бид үнэхээр ярьж байгаад л Үндсэн хууль зөрчсөн бол Үндсэн хууль чинь номер нэг шүү дээ.

Даширамд би нэг юм хэлье. Цогтбаатар дарга аа, та байнгын хорооны дарга байж. Одоо манай Их Хурал дээр хүртэл ийм тэнэг систем байгаа шүү дээ. Ямар тэнэг систем байгаа гээч. Их Хурлын гишүүний санаачилсан хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг манай Их Хурлын Тамгын газар хянадаг байвал яах вэ. Ийм байж болдог юм уу. Би ганц тогтоолын төсөл санаачилсан чинь намайг юу гэж алсан гэхээр энэ Алтанхуягийн санаачилсан төсөл Үндсэн хууль зөрчиж байна гээд. Би тэгээд хуц гэсэн юм. Чи Үндсэн хуулийн цэц юм уу. Их Хурлын Тамгын газар Үндсэн хуулийн цэцийн ажлыг хийх юм уу. Одоо энэ хуулиа хүртэл эргэж

харах ёстой шүү дээ. Тийм биз дээ. Энэ чинь яах гэж Үндсэн хуулийн цэц байгаа юм. Энэ Алтанхуягийн санаачилсан хуулийн төсөл юм уу. Тэмүжиний санаачилсан хуулийн төсөл Үндсэн хууль зөрчиж байна гэвэл Үндсэн хуулийн цэцэд өгөөд Цэцийн шийдвэрийн дараа гардаг юмыг манай нэг даргын пальдага амьтан Алтанхуягийн энэ нь Үндсэн хууль зөрчиж гаргаж байгаа юм. Би энэ шинэ гишүүд та нарт хэлж байгаа юм. Ийм юмтай анхнаасаа тэмцэгдэхгүй болохоор ингээд л новшироод л хогийн хогийн юм хийгээд л. Өөрөө Их Хурал төрийн эрх барих дээд байгууллага мөртөө өөрөө Үндсэн хуулийн цэцийн үүргийг нэг албан тушаалтан давхар гүйцэтгээд явж байдаг. Иймэрхүү иймэрхүү юмыг жаахан анхнаасаа ойлголцоод засчихмаар байгаа юм. Би энийг зүгээр таширамд хэлж байгаа юм шүү. Би өмнө нь хэлсэн. Тэгээд ерөөсөө ажил болгохгүй юм. Тэгээд л дарга нар нь тэр байтугай энэ даргын дэргэдэх зөвлөлийг индпендент болгох хэрэгтэй байгаа байхгүй юу. Занданшатарын доор биш. Одоо хэн болчихлоо. Амарбаясгалангийн дор биш. Индпендэд байх ёстой байхгүй юу. Тэгээд тэр хэлэлцэх асуудлаа хэдүүлээ нэг ярьж байгаад тэгээд дундаасаа гаргадаг ийм байхгүй бол бүх газар даргын систем тогтчихсон. Манай Байнгын хороо дээр ч гэсэн. Тэгэхдээ манай дарга арай гайгүй л дээ. Ёстой пальдагдлаа.

Дам.Цогтбаатар: Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Цэцийн дүгнэлтийн тухайд би бол Энхбаяр гишүүнтэй бүрэн санал нэг байна. Энэ дүгнэлт дээр бас нэг зүйлийг бид нар анзаарч харах ёстой. Түүхчилсэн байдлаар судалгаа хийж оруулсан нь бол маш сайшаалтай байна. Өөрөөр хэлбэл бид нарын өнөөдөр 2024 онд түр саатуулах гэдгийг сая яг Сайнзоригийн хэлдгээр ямар нэгэн ийм тортой хаалганы цаана байшин дотор хийснээ бид нар түр саатуулах гэдэг ойлголт руу

хүрчихсэн байна гэдгийг бол энэ дээр маш сайн тодорхой дүгнэсэн байгаа.

Гэхдээ анх 1993 онд түр саатуулах гэдэг бол цагдаагийн байгууллагын ажилтан буюу эрх бүхий байгууллагын ажилтны мэдэлд тэр хүний бие махбод очсон цагаас эхлээд энэ бол хүний эрхийн хязгаарлалт үйлчилж байгаа гэж байгаа юм. Тэгэхээр бид нар ерөөсөө зөвхөн байшин барилгаар ерөөсөө энэ түр саатуулах гэдгийг битгий хараасай гэдгийг бол энэ дээр бол онцолж хэлэх хэрэгтэй. Тэгэхээр тийм учраас энэ 6 цагийн зовлон буюу энэ дэд бүтцийн зовлонгоос болоод бид нар хүний эрхийн ийм хязгаарлалтад ийм гоомой байдлаар бол ерөөсөө хандаж болохгүй. Бүтэн 6 цагийн турш юу болох вэ. 6 цагийн дотор хүргэж аваачиж өгч чадахгүй мөртөө цагдаагийн мэдэлд тэр хүн байна. Морьтой, машинтай, ямар нэгэн байдлаар. Тэгэхээр энэ бол өөрөө бүтэн хүний эрхийн хязгаарлалт аль хэдийн үүсчихсэн байгаа гэсэн үг. Тэгэхээр баривчилснаас эхлээд, саатуулах байранд хүргэснээс эхлээд хугацаа тоолно гэдэг бол хүний эрхийн зөрчил мөн гэдэг энэ дүгнэлтийг хүлээж авах хэрэгтэй. Дээрээс нь энэ дүгнэлт дээр бас нэг анхаарал татсан зүйл нь энэ саатуулах байрны тоо. Цагдаагийн байгууллагын дэргэд 3, Тагнуулын байгууллагын дэргэд 3 гэснээ энэ болохоор прокуророос өгч байгаа тоо. Гэтэл цагдаагийн байгууллага болохлоор 25 гэдэг ч гэдэг юм уу. Тэгэхээр нөгөө саатуулах байрны стандарт хүртэл маш том асуулт. Үүний ард асуудал байна гэж харагдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Цэцийн дүгнэлтийг бол хүлээж авах нь зүйтэй гэж бодож байна.

Дам.Цогтбаатар: Баярлалаа. Би энд товчхон бас хэдэн үг хэлье гэж бодож байна. Энэ Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлт зөв. Одоо энэ дээр манайхан бас яг энийгээ дэмжиж, үг хэлж байгаад би талархаж байна.

Сайнзориг гишүүний ярьж байгаа асуудлаар бол амьдрал угаасаа өөрөө баян учраас ийм асуудал байгаа бол цагдаагийн газар энийгээ хуулиа гүйцээгээд боловсруулаад оруулж ирэх ёстой. Яагаад гэвэл өнөөдөр одоо энэ үйлчилж байгаа хуулийн 26.1-д саатуулах хугацааг 6 цаг гээд заачихсан байгаа байхгүй юу. Энд өөрчлөлт оруулах ямар ч боломжгүй байна шүү дээ. Тэгэнгүүтээ одоо өөрийн чинь ярьж байгаагаар 26.2 дээрээ бол хэзээ эхлэхийг нь заагаад өгчихсөн. Тэгэхдээ саатуулах хугацаагаа 6 цаг гээд заачихсан. Энийг одоо өөрчлөх боломжгүй энэ хуулиараа. Тэгэнгүүт тэр 6 цагт чинь Сайнзориг гишүүн ээ, би хүнд очоод би таныг саатуулж байна гэж хэлээд л юун гав зүүх, би тэгж хэлээд л тэр хүний эрх зүйн байдал өөрчлөгдчихөж байгаа байхгүй юу. Намайг тэгж хэлсний дараа тэр хүн миний үгийг сонсохгүй. Цаашаа нэг алхахад л хууль хяналтын байгууллагын хүний өгсөн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй гээд тэр хүн өшөө зүйл анги нь нэмэгдэнэ шүү дээ. Ингээд тэр хүний эрх ингэж хэлээд л хязгаарлагдчихаж байгаа байхгүй юу. Одоо тэр далайн эрх зүйтэй орнуудын *miranda law* гэдэг чинь Америкийнх чинь бол яг тэр баригдаж байгаа хүндээ тэрийг заавал хэлээд л нөхцөл байдал нь өөрчлөгдөж байгаа юм. Хэлээгүй байхад тэр хүний эрх хөдлөхгүй байж байгаад суллагдаад гарсан шүү дээ. Миранда Кейс гэдэг дээр чинь танд ийм эрх байгаа гэдгийг нь хэлэлгүйгээр бариад л тэгээд тэр хүн дараа нь хэрэг хийсэн байсан ч тэгж бариагүй учраас тэр хүн суллагдаад гарч байгаа байхгүй юу. Тэгэхээр хууль өөрөө заасан заалтынхаа хүрээнд абсолют хүчтэй тэрийг дагахаас өөр ямар ч үгүй. Бид нар тэгэхлээр толгойдоо энийг ийм байгаа юм гэж гүйцээж бодож ямар ч гэсэн цагдаа хүн газар дээрээ тэрийг гүйцээж бодож ийм байя. Яагаад гэвэл ийм логиктой юм гэж хууль тогтоох байгууллагын өмнөөс тэр хүн бодож хийж болохгүй л байхгүй юу. Тэгэхээр амьдралыг би ойлгож байна. Одоо жишигээр би саатуулчаад нээрээ хянах

байр луу 12 цаг бид нар явбал тэр 12 цаг тэр хүн аль хэдийн хяналтад орчихсон явчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь тэгээд 12 цаг яваад, дараа нь аваачиж хийж байж 6 цаг эхэлнэ гэвэл наад хүн чинь энэ 26.1 дээр чинь 6 гэсэн заалтыг 12 цагаар зөрчхөж байгаа байхгүй юу. Энийг 1 минутаар ч зөрчиж болохгүй. Өнөөдөр байгаа бидний батлаад өгсөн хууль яг ийм байгаа.

Тэгэхээр амьдралтайгаа тэр нийцүүлэх гэж байгаа бол холбогдох байгууллага энэ саналаа оруулж ирэх ёстой л гэж би хэлмээр байна. Түүнээс амьдрал дээр нээрээ ийм юм бас энэ том оронд чинь байгаа. Тэгэхээр энэ дээр Үндсэн хуулийн цэц хүний эрхээ барьж шийдвэр гаргаж байгаа. Түүнээс цагдаагийн зовлонг ойлгож биш. Хүний эрхээ барьж шийдвэр гаргаж байгааг бид нар зөв гэж үзэж байгаа.

Энэ дээр бас би зүгээр гишүүддээ хандаад хэлэхэд энийг хардаа. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт халдашгүй чөлөөтэй байх хэрэгтэй гээд. Манай Монголын иргэд ийм шүү дээ. Халдашгүй чөлөөтэй. Энэ нөгөө Их Хурлын гишүүд дархан эрхтэй гээд байгаа чинь төрийн процесст хэлж ярьж байгаа үгэндээ л тэр дархан эрхийг нь өгөөд байгаа болохоос биш хийж байгаа ажилд нь өөрөөр хэлбэл, бусад юманд уг нь хамаарах ёсгүй юм байгаа юм шүү дээ. Бусад юманд иргэдтэйгээ адилхан. Иргэд халдашгүй байхгүй юу. Тэрнээс давсан дархан эрхтэй байж яах гээд байгаа юм. Бусад юман дээр иргэдтэйгээ адилхан л уг нь халдашгүй байх ёстой. Энийг бас би онцолж хэлмээр байна. Тэгэхлээр ер нь цаашидаа яг энэнд нийцүүлсэн хуулийг бодох хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүй 216 дархан эрхтэй юу ч хийхэд болдог тийм онцгой эрхтэй амьтад байх бол би хэрэггүй л болов уу гэж бодож байгаа.

Харин хийж байгаа ажил нь өөрөө тэр дархан эрхээр хамгаалагдсан байх ёстой л гэж би бодож байгаа. Тийм

учраас одоо энэ дээр Үндсэн хуулийн юуг саналыг хүлээж авъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ингээд Цэцийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Цэцийн дүгнэлтийг хүлээж авъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Эхлээд туршилтын санал хураагаадаахья даа. Тэгвэл энэ зүгээр ажиллаж байна. Нөгөө Цогтбаатар. Минийх зүгээр гарч байх шиг байна. Минийх зүгээр гарч байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 26.2 дахь хэсэгт “энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 81,3 хувиар санал дэмжигдлээ. Нара гишүүнийг дэмжсэнээр протоколд бүртгэж авъя.

Би харин ойлгож байна. Гэхдээ наана чинь хүний эрхээ барьж хүний талдаа бид нар шийдээ гаргана. Түүнээс бид нар хууль тогтоох процессоо бүгдээрээ мэдэж байгаа. Энэ хуулийг цагдаа өөрөө л оруулж ирсэн байгаа шүү дээ. Тэгж л байгаа шүү дээ. Тэгээд цагдаагаас санал авч цагдаа энэ дээр саналаа хэлж байж оруулж ирсэн байгаа. Одоо ажил дээр нь энэ дээр хүндрэл гарахаар байгаа бол энийгээ түргэхэн л оруулж ир. Тэр болтол энэ хууль энэ үг, үсгээрээ үйлчлээд явна. Угаасаа хууль тайлбарлах 1 дүгээр дүрэм үгээр нь тайлбарладаг биз дээ. Тэгээд тэндээс ойлгомжгүй байвал бид нар агуулга руу контекст руу ордог шүү дээ. Энэ дээр чинь үгээр маш тодорхой, Монгол хэлээр заагаад өгчихсөн байхгүй юу. Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн энэ

дүгнэлт нь би зөв гэж үзэж байгаа юм. Тэгээд ахиад би энэ дээр та нарын яриад байгаа асуудлыг ойлгож байгаа. Түргэхэн л тэр асуудлаа тэгвэл холбогдох байгууллага ажлаа хийх үүднээсээ оруулж ирэх ёстой. Хууль зүйн яам, тэр цагдаагийн газар нь Хууль зүйн яамаараа дамжаад оруулж ирэх хэрэгтэй. Энийгээ янзлах гээд оруулж ирвэл би ч өргөн барьж өгөхөд нь туслаад дэмжээд явна.

Дараагийн санал хураалт байна.

2.Цагдаагийн албан тухай хуулийн 26.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэдийнхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 75 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд энэ асуудлаар санал хураалт явуулж дууслаа. Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 3 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хуралд энэ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 3 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд нэг шинэ гишүүн Баасанжаргал гишүүн уншаад танилцуулчих уу. Баасанжаргал гишүүн танилцуулна.

15.59 цаг.

2 дугаар асуудалдаа оръё. Бусад асуудал.

2 дугаар асуудал бол Баярмаа гишүүн ирсэн байгаа. Тэгэхээр яах вэ энэ дээр чинь одоо Баярмаа гишүүн өөрөө горимын санал гаргах ёстой болж байна уу.

Өчигдөр Байнгын хороогоор бид нар энэ сонсгол явуулах асуудлыг хэлэлцээд товыг нь тогтоож өгсөн байгаа. Гэхдээ үүнтэй холбогдуулаад сонсголыг удирдаж явуулах Сайнзориг гишүүн санаачилга гаргасан гишүүдтэй ярьж зөвлөлдсөний үндсэн дээр энд холбогдох журам бол гараагүй байгаатай холбогдоод энэ товыг бол өөрчлөх зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа.

Тэгэхээр би Байнгын хорооны даргын хувьд бол санаачилга гаргасан гишүүд өөрсдөө энэ асуудлыг тавиагүй тохиолдолд би бол энийг өөрчлөхгүй гэсэн байр суурьтай байгаа. Тэгэхээр санаачилга гаргасан гишүүн горимын санал бол гаргаж болно. Энэ яг журамтай холбогдуулаад. Тэгэхээр Сайнзориг гишүүнтэй та хэд маань зөвлөлдсөн байгаа гэж бодож байгаа. Та энэ асуудлаар энэ товыг өөрчлөх асуудал дээр санал бодлоо хэлэх үү. Баярмаа гишүүний микрофоныг өгье.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Сайнзориг гишүүнтэй бид 2 бол яг энэ асуудлаар уулзаж, ер нь маргааш өглөө уулзъя гэж уг нь Золжаргал зөвлөхтэй ярьсан байсан. Саяхныг хүртэл тулгамдсан асуудал юу байсан бэ гэвэл сэдэв. Би бол ер нь тэр нийтийн сонсгол дээр байсан тэр 4 төрлийн 1-ийг тэр чигт нь тавиад л явуулсан. Энэ хүрээнд мэдээж сонсголын өдөр нь хэдэн өдөр байх юм гэдгээсээ хамаараад аль сэдвийг нь авч ярих вэ гэдэг дээрээ тогтё гэсэн бас тийм байр суурьтай байсан. Ер нь бол 3 том чиглэл байна гэж харсан. Мэдээж нөгөө 21 настай талийгаач залуугаас үүдээд эрүүдэн шүүх, хүнтэй хэрцгийгээр харьцах гэдэг ийм нэг асуудал. Олон байгууллага хамрагдана.

Хоёрдугаарх нөгөө хэвлэлийн эрх чөлөө.

3 дахь нь бол жагсаж цуглах, үг, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө гэдэг

ийм 3 үндсэн хүрээнд ер нь ингээд тавьчихъя. Тэгээд болбол 3 өдөр дараалж хийдэг ч юм уу гэсэн шүү юм зүгээр ингээд бодоод байж байсан. Тэгээд мэдээж яг ингээд хийхдээ тулбал ярьж байж шийднэ гэж бодсон. Тэгээд өчигдрийн мэдээллээр бол 1 өдөр л товлосон юм байна. Тэгээд 9 сарын 10-нд гээд. Тэгэнгүүт нэгэнт ганцхан өдөр товлож байгаа юм бол энэ олон асуудлыг ярьж амжихгүй учир 1 сэдэв рүүгээ оръё гэдэг дээр ерөнхийдөө ойлгоод, тэгээд сэдвээ ерөнхийдөө би бас анх нөгөө мотивийн гарсан тэр сэдэв рүүгээ орж байгаа. Өөрөөр хэлбэл нөгөө Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5, Үндсэн хуулийн 16.13 нөгөө эрүүдэн шүүх, хүнтэй хэрцгий, хүнлэг бус хандахаас ангид байх, хүний эрхийн хэрэгжилт гэдэг юм уу. Сэдвээ бол ингэж тогтсон. Товтой холбоотой тэр журам энэ тэрийн талаар бол би сая сонслоо. Тэгэхээр миний зүгээс бол энэ товыг хойшлуулж өгнө үү гэдэг тийм санал гаргах үндэслэлгүй гэж бодож байгаа. Яагаад гэвэл би товыг тогтоогоогүй. Тэгэхээр би тов тогтоогоогүй учраас би энийг хойшлуулж өгнө үү гээд ингэх бол ер нь бол үндэслэлгүй гэж бодож байгаа.

Тэгэхээр магадгүй Хүний эрхийн дэд хороо юун дээр үндэслэж тэр товыг тогтоосон юм. Тэгээд тэр нь яагаад болохоо больсон юм гэдэг дээрээ үндэслээд өөрсдөө тэр товоо өөрчлөх ийм асуудлыг л хийвэл хийх байх. Миний зүгээс бол товыг өөрчилж өгнө үү. Яагаад гэвэл журам байхгүй юм байна гэдэг бол миний асуудал биш байх л гэж бодож байна л даа.

Дам.Цогтбаатар: Сайнзориг гишүүн саналаа хэлэх үү.

П.Сайнзориг: Манай гишүүд бас их чухал асуудлаар хяналтын сонсгол хийе гээд санаачилга гаргаж байгаа. Цогтбаатар дарга ч гэсэн энэ дээр бас маш шуурхай хандаад, зохион байгуулалт хийе гэж бодож байгаа боловч энэ хууль маань бас 2024 оны хаврын чуулганаар 5

сард батлагдсан хууль юм байна. Энэ хуулийг хэрэгжүүлэх тэр дагаж гарах дүрэм журмууд нь одоохондоо гараагүй байгаа юм байна. Тэгэхээр би зүгээр ингээд харахаар энэ товыг дахин зарлах асуудал байхгүй бол болохгүй болчихоод байгаа юм. Өчигдөр Цогтбаатар дарга яг Баярмаа гишүүний хэлж байгаа шиг энэ сонсгол явуулах төрлөөр нь тавьчихаар сэдвийг бид 2 тохир гэж байгаа юм. Тэгэхээр би Байнгын хорооноосоо давж шийдвэр гаргах буюу энэ Монгол Улсын Их Хурлын хяналтын тухай хууль дээр 121.2 дээр сонсгол явуулах сэдэв заавал байж байж тов зарлагдана гэж байгаа. Тэгэхээр энэ өчигдрийн тогтоолоо хүчингүй болгоод, өнөөдөр бас яг сэдвээр нь товоо гаргаад, санаачилгаа Баярмаа гишүүн, Тэмүүжин гишүүн энэ тэр гаргачихвал яг нийцэх гээд байна. Тэгэхгүй бол нөгөө нэг бид хэд бас ерөнхий юм тавьчихсан. Түүрүүн бас Тэмүүжин гишүүнтэй ярьсан.

2 дугаарт яах вэ энэ 126.5 гээд нэг заалт байгаа юм. Би бас энэ хяналтын сонсголыг мэдээж хуульд нийцүүлж явуулах үүрэгтэй ийм албан тушаалтай юм байна лээ. Энийгээ ингээд бариад явна гэхээр 126.5 дээр Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах нарийвчилсан журмыг Улсын Их Хурлын тогтоолоор батална гэдэг заалттай. Нөгөө тогтоол маань батлагдаагүй байж байхад би одоо бас янз бүрийн дэг зохиогоод ерөнхийд нь практик нь ийм байна гээд явахаар бас ямар нэг хүндрэлтэй юм байх юм болов уу гэдэг ийм зүйлүүд байна. Тэгэхээр энэ нөхцөл байдлуудыг бас бодолцоод товоо бас яг санаачилж байгаа гишүүд маань бас дахиад нэг бодолцоод гаргачхаач гэдэг зүйлийг би бас хүсмээр байгаа юм. Уг асуудлыг одоо яригдаж байгаа сэдвүүдийг бол Хүний эрхийн дэд хороо дээр ярилцаад явахад бол бүрэн бололцоо байна. Энэ яг чиг үүрэг ч давхцахгүй, албан ёсны бас шийдвэр гаргах ч бололцоотой. Тэгэхээр энэ асуудлуудыг тал талаас нь бас Хүний эрхийн дэд хороо дээрээ бас Хууль зүйн байнгын

хороо дээр ярилцаад бас наана нь явж байж болно. Тэгэхээр энэ зүйлүүдийг бас гишүүд маань бодолцоод, дахиад ингээд хуульд нийцүүлээд зөв болгоод өгчих бололцоо байгаа юу л гэдэг л ийм л зүйлийг би хэлмээр байгаа юм.

Дам.Цогтбаатар: Тэгэхээр Баярмаа гишүүн ээ, энэ чинь товын асуудал биш, сэдвийн асуудал болж гарч ирж байна шүү дээ. Тэгэхээр та тэгвэл сэдвээ өгөх үү. Би тэгээд шинэ товтой бүр яг тодорхой сэдвээр санал хураалгаадахъя. Баярмаа гишүүний микрофоныг өгье. Энэ юутай явсан нь зөв шүү.

Ж.Баярмаа: Бас яах вэ ерөнхийдөө шинэ гишүүн тул сонсгол ямар процессоор яаж явдгийг мэдэхгүй. Яах вэ аминдаа бас холбогдох Байнгын хорооны зөвлөхүүдтэй бол санал солилцож ингэж шийдсэн. Тэгээд бас аминдаа энэ хуулиудыг бол нь жсоохон харсан. Тэгээд яг сэдэв байх ёстой гэдэг 126.5 нь дэгийн тухай хууль юм уу. Эсвэл энэ аль хуулийн 126.5 дугаар заалт. Дэгийн тухай. Энэ заалтыг бол би яг үнэндээ хараагүй юм байна. Тэгээд эхлээд бол яг энэ тодорхой сэдэвтэй явсан юм. Тэгээд манай гишүүд болохоор маш олон асуудал байна Хүний эрхийн. Тэгээд нэгмөсөн ингээд ярьчихсан зүйтэй гээд. Ингээд нөгөө нарийвчилсан сэдвээ өргөн болгоод, Ингэж байгаад тэр дундаас хамгийн тулгамдсан сэдвүүдээ ярья гэж шийдээд, буцаагаад өргөжүүлээд тавьчихсан юм. Сэдэв дээр. Тэгэхдээ энэ бол болохгүй сэдэв гэж бол байхгүй байх. Тийм нарийвчилсан сэдэв байх ёстой гэдгийг бол би дахиад жсоохон ойлгохгүй байна. Тэртээ тэргүй сонсгол хийх төрөл гээд байж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ төрлийн дагуу хийе ээ л гээд л ингээд л саналаа өгөхийг бол болохгүй гэж би бол мэдсэнгүй. Тэгэхдээ одоо яах вэ дахиад тэрийг заавал ч үгүй тэгэх шаардлагатай гэж үзэж байгаа бол сэдвээ өөрчлөөд өгөхөд бол бэлэн байна. Товыг нь ч гэсэн. Би бол товыг шийдэхгүйгээс хойш журам нь чухам

хэзээ гарах юм. Тэрэндээ хамаарч тов нь гарч таарах юм шиг байна шүү дээ.

Дам.Цогтбаатар: Хуулиараа өөрөө заавал заачихсан журам байгаа юм байна. Би энэ дээр нэг ийм юм хэлмээр байна. Ер нь бол одоо ингээд хууль хэрэглээ гэдэг чинь өөрөө энэ практик нь дараа нь хуулийн тайлбар дээрээ эргээд хэрэглэгддэг байх. Аливаа нэгэн шүүх дээр яваад ороход энэ хуулийг ингээж ойлгоно. Ялангуяа бид нар хууль тогтоогчид учраас бүр хуулийг цаанаасаа юу гэж бодож хийснийг хамгийн түрүүн ярих хүмүүс нь угаасаа тэр хууль тогтоогчид байхгүй юу. Тэгэхээр бид нарын энэ хэрэглээ юуг тогтоож өгөх гэж байна л даа. Шинэ хэм хэмжээг. Жишээлбэл Тэмүүжин гишүүн ээ, энд нэг юу гарах нь байна шүү дээ. Одоо тэр ерөнхий чиглэлээр болохгүй сэдэв тэр нөгөө 126 дээр заачихсан сэдэв гэдэг чинь чиглэлээсээ нарийвчилсан сэдэв гэж бид нар ойлгож эхлэх нь байна шүү дээ. Тэгэнгүүт аливаа гишүүн тэр тодорхой чиглэлийг заахыг бол тэр 126-д заасан сэдэв гэж үзэхгүй гэж бид өнөөдөр ёстой практик хэрэглээгээрээ заах болчихож байна шүү дээ. Харин тийм. Ер нь бол тийм байгаа биз. Наана чинь нэг тийм асуудал өөрийн эрхгүй бол гарч байгаа юм. Тэмүүжин гишүүнд микрофон өгье.

Х.Тэмүүжин: Ерөнхий логикоороо бол ийм байхгүй юу. Улсын Их Хурал тодорхой шийдвэр гаргахын тулд сонсгол зохион байгуулж мэдээлэл авч байгаа. Сонсгол гэдэг бол мэдээлэл авахад зориулагдсан хэрэгсэл. Тэгснээс биш сонсгол зохион байгуулахын тулд сэдэв хөнддөг тийм үйл явдал ерөөсөө байхгүй. Тэр сэдэвтэй холбоотой шийдвэр гаргахын тулд сонсгол зохион байгуулна гээд мэдээлэл авах гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ мэдээлэл авахад юу шаардлагатай болох вэ гэхээр тэр сэдвээр нь ямар хүмүүсийг мэргэжилтнээр дуудах юм, гэрчээр дуудах юм, хариуцаж байгаа ямар албан тушаалтан дуудах юм гэх мэтчилэн

нөгөө замын зургууд чинь гарч ирэх ёстой юм. Сэдэв өөрөө нарийвчлагдсан тодорхой байхгүй өргөн сэдэв тавьчих юм бол дуудах хүмүүс чинь ингээд маш бүрхэг болно. Мэдээлэл авах ажиллагаа үр ашиггүй болно. Ард нь шийдвэр гарч чадахаа байчихна. Тэгэхээр хууль өөрөө юу гэж заасан бэ гэхээр ийм төрлөөр сонсгол зохион байгуулж болно гээд сонсголын 4 төрөл байгаа билүү. 4 төрөл байгаа юм. Тэгэнгүүт тэр төрөл дотроо хүний эрх, эрх эрх чөлөөтэй холбоотой гэнгүүт би хүний эрх, эрх чөлөөтэй энэ сэдвээр, эрүү шүүлттэй нь холбоотой, ядууралтай холбоотой, эсвэл тэр утаатай холбоотой ч гэдэг юм уу энэ дотроо сэдвээ зарлавал тэр сэдвийн хүрээнд хариуцаж байгаа албан тушаалтнуудыг дуудах ёстой болно. Гэрчүүдийг дуудах ёстой болно. Хохирогчийг дуудах ёстой болно. Яг ийм л ажиллагаа байгаа юм. Тэгэхээр сэдэв хэрэгтэй болчихоод байгаа байхгүй юу. Нарийвчлах. Яагаад гэвэл нөгөө дуудаж байгаа хүн би юунд хариу өгөх вэ гэдгээ мэдэх хэрэгтэй. Тэр ийм асуултууд асууж байгаа энэ мэдээллээ боловсруулж ярь, ийм хариугаа өгөх гэж өөрийн чинь ажил үүрэг дээр ийм юм байгаа учраас энэ дээрээ тайлбар хий гэж ярих хэрэгтэй болчихож байгаа юм.

Дам.Цогтбаатар: Тэгэхээр Баярмаа гишүүн ээ, өөрт чинь шинэчлээд сэдвээ өгөх боломж байна уу. Тэгвэл би одоо энийг чинь томъёолж оруулаад санал хураалгачихъя. Баярмаа гишүүний микрофоныг өгье.

Ж.Баярмаа: Дэгийн тухай хууль 126.4 юм байна тээ. Эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий хандлагаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт гэж л би томъёоллоо л доо. Яах вэ энэ чинь яг энэ үгээрээ шахам нөгөө Үндсэн хуулийн 16.13-д байгаа. Дээрээс нь нөгөө Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаарт бас байдаг юм байна. Тэгэхээр болж байна уу. Эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий хандлагаас ангид байх. Зөвхөн эрүүдэн шүүхээс ангид байх хүний эрх

гэхээр нөгөө хэрцгий, хүнлэг бус хандлага гэдэг нь орхигдох гээд байна. Энэ чинь асар нарийн ялгаатай юм байна лээ шүү дээ. Тэгэхээр эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий хандлагаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт гэж болж байна уу. Яг ингээд гурвууланг нь бид нар ярина гэсэн үг. Тэгэхээр тодорхой байгууллагууд нь ч тодорхой тээ.

Дам.Цогтбаатар: Би тэгвэл давтаад уншаадахъя. Өөрийнхөө тэмдэглэснийг. Эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий хандлагаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн асуудлаар сонсгол зохион байгуулъя гээд. Тийм ээ. Сэдэв нь ийм байх юм байна. Тэрийг бол ишидвэр гаргахдаа редакторын юугаа манайхан засаад хийчих байх. Тэгвэл өчигдөр Байнгын хорооны хурлаар хэлэлцэж, хүний эрхийн асуудлаар сонсгол зохион байгуулах хурлын сэдэв, товыг тогтсон байгаа. Тэгээд энэ дээр санаачилга гаргасан гишүүдийн илүү тодотгож гаргаж байгаа санаачилгыг хүндэтгэн үзээд энэ дээр товыг шинэчилж, сэдвийг илүү нарийвчилж тогтоох энэ саналыг би дэмжиж байна. Тэгээд би энэ санал хураалгах тогтоолын төслийг нь танилцуулъя.

2024 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар баталсан “Сонсголын тов тогтоох” Байнгын хорооны тогтоолтой холбогдуулан товыг дахин тогтоох. Товыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөр тогтоож, зохион байгуулах. Сэдвийг Эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий хандлагаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн асуудлаарх сонсгол зохион байгуулна гэсэн ийм томъёоллоор санал хураая. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалтыг хүчингүй болгоё. Түр хүлээж байя. Сонсгол даргалагчаар Сайнзориг гишүүн өчигдөр нэгэнт угаасаа баталчихсан. Гэхдээ өнөөдөр нэгэнт тогтоол шинэчилж орж ирж байгаа болохоор Сайнзориг гишүүн даргалахаар оруулъя. Тэгээд энэ 2 шинэчлэл орсон. Сайнзориг дарга

даргалах хэвээрээ үлдсэн ийм тогтоолыг баталъя. Баярмаа гишүүний микрофоныг өгье.

Ж.Баярмаа: Даргалах дээр ямар зохицуулалт байгаа юм бол. Яах вэ, тэр нөгөө түр хороо байгуулаад, хэнээр даргалуулах вэ гэдэг нь бол тэр түр хорооны гишүүд дундаасаа сонгогдоно гэж бол уншсан. Яг энэ хяналтын сонсгол буюу түр хороо бус ийм үед яг тэр, энэ ингэж даргална гэсэн зохицуулалтыг бол би хайгаад олоогүй. Тэгэхээр яах вэ, би бол өөрөө энд санал гаргаж болно гэж ойлгож байгаа. Гар өргөж санал өгөх эрхгүй л болохоос биш санал гаргах эрхтэй гэж бодож байгаа юм. Тэгэхээр миний уг нь санал юу байсан бэ гэвэл нэгэнт санаачилсан би мэдээж болдоггүй юм гэхэл ер нь бол Хүний эрхийн дэд хорооноос ч гэсэн ахална гэсэн заалтыг би бас олоогүй. Энэ дээр бол одоо ямар ч зохицуулалт байхгүй юм байна лээ. Тэгэхээр одоо бас нэг шинэ жишиг тогтоох шаардлагатай л болж байх шиг байна л даа. Магадгүй заавал ч үгүй тэр Дэд хороонд харьяалагдаж байгаа хүмүүсээсээ энийг удирдах ёстой гэдэг жишиг, хуулийн заалт бол байхгүй байх. Хэрэв тийм жишигийг тогтоож байгаа бол би бол энийг санаачилсан энэ гишүүдээс Тэмүүжин ч юм уу, Эрдэнэболд гишүүнээр уг нь удирдуулъя гэж хүсэж байгаа байхгүй юу. Дээрээс нь би нэг ийм юм бас халти сонссон. Зүгээр би бол хуулиас хайгаад олоогүй. Санаачилж гарын үсэг зурсан гишүүдээс даргалуулдаггүй гэдэг нэг ийм юм яригдсан сураг байна өчигдөр. Тэгэхээр энэ бол ямар хуулийн заалтаар ийм байдаг юм бэ? Энийг хэрвээ мэдсэн бол одоо бас бид нар мэдэх л ёстой байж гэж бодож байгаа ийм асуулт бөгөөд санал байна.

Дам.Цогтбаатар: Баярмаа гишүүн ээ, би энэ дээр өөрт чинь маш тодорхой хариулт хэлье. Хүний эрхийн асуудал аль нэг намын асуудал биш. Би өөрийн чинь асуудал аваад ороод ирэхэд эд нартай муудалцаж байгаад дэмжээд явуулж

байна. Түүнээс би журам гээд яриад яг эрх зүйн техникийн асуудал яригдвал наадхыг чинь зогсоохоор байна. Би та нарын нүдэн дээр энэ хэдтэй маргаж байгаад явуулж байгаа биз. Тэгээд 22 нэг намын гишүүн зурчихсан байхаар ядаад 1 намаас ганцхан хүн оруулаад, яагаад гэвэл энэ бусад намуудаасаа оруулъя. Энэ хүний эрхийн асуудал яригдаж байгаа байхгүй юу. Ардчилсан намын хүний эрх гэж байхгүй. Монгол Ардын намынх гэж байхгүй. Наад хүний эрхийн чинь асуудлыг би нам дотроо муу хэлүүлж байгаад, зүтгүүлсээр байгаад өнөөдөр энэ Их Хурал дээр номер нэг ярьдаг асуудал болгосон байгаа.

Анх би оруулж ирж байхад намайг шоолоод инээгээд Монгол Улсад хүний эрх шиг бүрэн хангагдчихсан юм байхгүй гээд энэ танхимд хөөж байсан тохиолдол бий. Өнөөдөр би юунд баяртай байгаа вэ гэхээр ийм асуудал байхгүй болчихсон байхгүй юу. Тэгэхээр ийм асуудал ярьж байхад, энэ хууль зүйн, ялангуяа чиглэлээрээ мэргэшихсэн ганцхан хүнийг оруулаад энэ юугаа удирдаад явуулахгүй бол наад журам чинь байхгүй. Маш нарийн асуудлууд амьдрал дээрээ гараад ирж байгаа биз дээ. Тэгэхээр л би энийг Байнгын хорооны даргын хувьд та нарын бүх саналыг дэмжиж өгөөд, ядаад жишээ нь саяын энэ техникийн асуудал эд нар чинь яах аргагүй л ингээд Сайнзориг дарга энэ дотроосоо гаргаж ирээд, тэгээд зогсооё гэхгүй явуулъя л гэж байгаа шүү дээ. Тэр үүднээсээ л санал гаргасан байгаа юм. Тэгэхээр саяын томьёоллоор тогтоолыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 62,5 хувиар санал дэмжигдлээ. Ингээд тогтоол батлагдлаа.

Тэмүүжин гишүүн үг хэлье. Үгээ хэлцгээ хэлцгээ. Тэмүүжин гишүүний микрофон өгье.

Х.Тэмүүжин: Протокол тэмдэглүүлэх гээд үлдээж байгаа. Ер нь бол энэ өөрөө нөгөө манай шинэ гишүүд

энэ хяналттай холбоотой хэсэг дээр зооохон туршилага бага байгаа. Тэгээд oversight hearing буюу ердийн хяналтын сонсгол зохион байгуулах ийм хүсэлт гаргасан. Тэгээд oversight hearing хэн зохион байгуулах вэ гэхээр Улсын Их Хурлын албан ёсны Байнгын хороо юм уу, Дэд хороо л зохион байгуулдаг. Тийм учраас Хууль зүйн байнга хороо энэ сонсголыг зохион байгуулах ажлыг хийж байгаа. Хууль зүйн байнгын хороо хийж байгаа учраас сонсголыг зохион байгуулах, сонсголыг даргалагч бол Хууль зүйн байнгын хорооны гишүүн байхаас өөр арга байхгүй болчихож байгаа. Баярмаа гишүүний нэг санал бол бас бид нар бодолцох ёстой. Улсын Их Хурлын санаачилсан гишүүд орж ирээд энэ сонсголыг хэнээр даргалуулах вэ гээд Хууль зүйн байнгын хороо дотор байгаа гишүүдийн нэрийг дэвшүүлэх эрх нь бол Улсын Их Хурлын гишүүдэд байгаа. Хэн даргалах вэ гэдгийг шийдэх эрх нь бол Улсын Их Хурлын Байнгын хорооны олонх. Зарчим нь ерөөсөө энэ.

Тийм учраас хэрвээ даргалагч дээр хөндлөнгийн санал байна уу, өөр хүн байна уу гэсэн бол Баярмаа гишүүн саналаа оруулж ирээд, санал хураалгах эрх бол бас хадгалагдаж байгаа байгаа шүү гэдгийг тайлбарлаж хэлэх ёстой байх.

Түр хороотой холбоотой асуудал бол энэ өөрөө Байнгын хорооноос гадуур явж байгаа. Улсын Их Хурлаас байгуулагдана гэсэн үг. Түр хороо байгуулагдаад, түр хороонд орсон гишүүд хэнээр энэ сонсголоо зохион байгуулж даргалах вэ гэдэг бол дотроо өөрсдөө шийднэ гэсэн үг. Тэгэхлээр энэ нөгөө oversight hearing учраас түр хорооны зарчмаар ерөөсөө үйлчлэхгүй. Энэ мэдээллүүдийг нь бас ингээд сайн өгөхгүй бол.

Дам.Цогтбаатар: Баярлалаа. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Ер нь өнөөдөр жишээлбэл Их Хурлын даргын хэлж байгаа үг, бас энэ хаалттай хуралдаа дээр Ерөнхийлөгч болон энэ тусгай чиглэлийн байгууллагуудын хэлж байгаа үг, одоо энэ улс төрийн нөхцөл байдал, бүс нутгийн олон улсын байдал гээд геополитикийн нөхцөл байдлаас болоод ер нь энэ хүний эрхийн асуудал бол урьд нь бол задгай явдаг байснаасаа илүү маш тийм болгоомжтой ярих, болгоомжтой гэдэг нь болох юм бол их нухацтай ярих бас сэдэв болчихсон. Ялангуяа нөгөө гадаад бодлогыг нэг цонхоор улс төржихгүй байх эд нар гэж байгаатай адилхан хүний эрхийн асуудал чинь бас тийм болчихсон. Одоо энэ Орос, Украйны асуудал дээр хүмүүс хувийн байр сууриа илэрхийлээд байгаа юм шиг боловч цаагуураа бас ингээд улс орны аюулгүй байдлын сэдэвтэй шууд холбогдчихоод байгаа юм.

Тэгэхээр ер нь бол Хууль зүйн байнгын хороондоо ингээд эхнээс нь бас Цогтбаатар дарга ийм зарчим хэлж байгаад бол би бас баяртай байгаа. Яагаад гэхээр олон Байнгын хороон дотроос Хууль зүйн байнгын хороо гэдэг чинь хамгийн л энэ хууль зүйд нийцэж байгаа эсэх тал дээр шийдвэр гаргаж байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар ядаж дотроо хүний эрхийн асуудал дээр ч гэсэн эхнээсээ ингээд ямар нэгэн тийм улс төрийн хазайлтгүйгээр ер нь энэ үндэсний эрх ашгаа бодоод, улс орныхоо эрх ашиг дээр байгаад, аль болох энэ сэдвийг ийм популизмаас ангид байлгах тал дээр нь ингээд хаа хаанаасаа хэн хэн хичээх ёстой гэж бодож байгаа. Тэгэхгүй яг энэ сэдэв дээр, ялангуяа тэр 21 настай хүүхдийн сэдэв дээр яг сонсгол хийгээд явахаар эмзэг байдлынх нь асуудал ил гарах болчихдог. Тэгээд тэр чинь эргээд нөгөө ард түмэнд талцал бий болгодог. Бодит мэдээллийг мэдэхгүй хүмүүс чинь бас ингээд янз бүрийн дүгнэлтүүд гаргадаг. Тэгээд ер нь бол юу гэдэг юм, шинэ парламент бүрдэж байгаа. Шинэ, хуучин гэхгүйгээр гишүүд маань яг энэ хүний эрхийн асуудал дээр

бүгдээрээ нэг ийм хль болохоор сэтгэлийн хөдлөлгүйгээр, маш прагматик, хууль зүйн хувьд бие биеэсээ суралцаад зарчимтай явах нь зөв байх л гэж бодож байгаа юм.

Бусад мэдээж шийдэлтэй зөндөө юмнууд дээр бид нар маргалдаж, үзэл бодол уралдуулж болох чиг ер нь бол энэ асуудал дээр тийм бодолтой байна. Яах вэ, цаашидаа бол манай энэ ахмад парламентч хүмүүс бас байж байгаа. Тэр нөгөө асуудал дээр бол аль болохоор консенсус байдлаар олон намын төлөөллүүд гарын үсэг зурж оруулж ирэх ч гэдэг юм уу, тэр дээр нь бол хэдүүлээ бас ярилцаад л явъя. Энэ процедурын асуудал дээр нэг их айхтар асуудлууд үүсэхгүй байх. Бага багаар суралцаад явчих байх гэж бодож байгаа.

Тэгэхээр ер нь энэ Хууль зүйн байнгын хороо гэдэг чинь маш чухал учраас энэ дээрээ бүгдээрээ бас нэг нэгэндээ хичээл заах ч юм уу, эсвэл янз бүрийн хатуу хөтүү үг хэлэхээс илүүтэйгээр илүү ухаан зарж, илүү энэ дээр бас үндэсний үндэсний эрх ашиг гэдэг юмаа бодож явах нь зөв байх гэж бодож байгаа. Одоо тэгэхээр гараад яг энэ сэдвээр ингээд хамаагүй улс төржихөөсөө өмнө эхлээд 7 хэмжин, 1 огтолдог тийм зарчимтай явах нь зөв байх л гэж бодож байгаа юм. Тэгээд яах вэ. Протоколд энийг үлдээчихье гээд хэлж байгаа юм.

Дам.Цогтбаатар: Баярлалаа. Ер нь цаашидаа ингэнэ хэдүүлээ. Хууль зүйн байнгын хороо бол ердийн Байнгын хороо биш. Хууль зүйн байнгын хороо.

Тэгэхээр би сая зөндөө юун дээр жишээлбэл процедур зөрчөөд үг хэлэх боломжууд олголоо. Өөрөөр хэлбэл тэр хүн үгээ хэлэх эрх чөлөөтэй гэж үзэж байгаа бол тэгээд нөгөө ёстой Улсын Их Хурал дээр ялангуяа гишүүд үгээ хэлэх эрхтэй гэдэг үүднээс би энэ боломжийг эхний хурал дээр олгоё гээд. Цаашидаа хэдүүлээ хурлынхаа дэгийг чанд сахиж,

Хууль зүйн байнгын хороо дээр хуулийнхаа дэг, журмыг дагахгүй болох юм бол бусад Байнгын хороо болон бусад иргэдээс хууль гэдэг чинь заавал дагах ёстой гэсэн ийм шаардлагыг тавих боломжгүй болж байгаа байхгүй юу. Тэгэхээр би сая бол юу дэгийн гадуур нэлээн хэдэн үг хэлэх эрх олголоо. Цаашидаа бол гишүүд маань дэгээрээ явна шүү гэдгийг би бас тэмдэглэж хэлмээр байна.

Ингээд өнөөдөр Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ ирсэнд баярлалаа.

16.24 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ